

Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны
өдрийн 1/167 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СПОРТЫН VIII НААДМЫН
ӨВЛИЙН ТӨРЛИЙН ШИГШЭЭ ТЭМЦЭЭНИЙ
НЭГДСЭН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 30.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын хэрэгжилтийг хангасан байна.

1.2.Монголын үндэсний спортын VIII наадмын өвлийн төрлийн шигшээ тэмцээний /цаашид тэмцээн гэх/ зорилго нь үндэсний уламжлалт спортын төрлүүдийг хөгжүүлэх, хамгаалах, уламжлалт тоглоом наадгайн зан үйл, үндэстний ёс заншил, соёлын өвийг өсвөр залуу үеийнхэнд өвлүүлэх, сурталчлан таниулахад оршино.

1.3. Үндэсний спортын тэмцээнд дараах зарчмыг баримтална.

- **ШИЛДЭГ:** Үндэсний спортын тэмцээнд оролцогчид нь үндэсний спортын төрлөөр төв, орон нутгаас шалгарсан шилдэг тамирчид байна.
- **ХҮРТЭЭМЖТЭЙ:** Улсын хэмжээнд үндэсний спортоор хичээллэгсдийн бүх нийтийн оролцоог хангаж, оролцогчдын эрхийг эрхэмлэн, иргэн бүр оролцох боломжийг бүрдүүлнэ.
- **ШУДАРГА:** Уламжлалт соёл, зан үйл, ил тод шүүлт, цэвэр шударга өрсөлдөөн, тамирчны ёс зүйг эрхэмлэнэ.
- **ТОГТВОРТОЙ:** Зан үйл, соёл, спортын бүтээгдэхүүнийг бий болгох, үндэсний соёлын биет бус өвийг хөгжүүлэх, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах.

Хоёр. Наадмын хөтөлбөр

2.1.Монгол Улсын хэмжээнд олон нийтийн дунд түгээмэл дэлгэрсэн үндэсний спортын өвлийн 2 төрлөөр зохион байгуулна.

2.2.Зохион байгуулагдах спортын төрлийн багийн бүрэлдэхүүн, шигшээ тэмцээн зохиогдох хугацаа, байршил:

№	Спортын төрөл	Оролцогчдын тоо	Хугацаа	Байршил
1	Мөсний шагайн харваа	Талын харваа - 6 хүн Цуваа харваа - 5 хүн Багийн харваа - 6 хүн	I/23-25	Улаанбаатар хот
2	Мөсний сурын харваа	Цуваа харваа - 12 хүн Багийн харваа - 12 хүн	I/23-25	Улаанбаатар хот

2.2.1.МӨСНИЙ ШАГАЙН ХАРВАА

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Баг	Бүгд
Талын харваа-6 хүн	цуваа харваа-5 хүн, багийн харваа-6 хүн	17 хүн

Хамрах хүрээ: Мөсний шагайн шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргээс анхан шат болон сонгон шалгаруулалтаас шалгарсан тус бүр 5 харваач нийт 150 харваач оролцоно.

Тэмцээний хугацаа: 2026.01.23-25

Тэмцээн болох газар: Хандгайт мөсөн гулгуурын талбай

Спортын холбоо: Монголын Үндэсний мөсний шагайн холбоо

2.2.2.МӨСНИЙ СУРЫН ХАРВАА

Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Баг	Бүгд
Цуваа харваа-12 хүн	багийн харваа-10 хүн сэлгээний 1 хүн дасгалжуулагч 1 хүн	12 хүн

Хамрах хүрээ: Мөсний сурын харвааны шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргээс анхан шат болон сонгон шалгаруулалтаас шалгарсан тус бүр 12 харваач нийт 360 харваач оролцоно.

Тайлбар: Цуваа харваа-12 хүн, багийн харваа-10 хүн байна. Цуваа харвааны тэмцээн 1 багаас хамгийн өндөр оноотой 1 тамирчинг шалгаруулна. Тэмцээнд "Өвлийн нум" - "Winter bow" болон эвэр нумтай оролцоно.

Тэмцээний хугацаа: 2026.01.23-25

Тэмцээн болох газар: Налайх дүүрэг Цонжин болдог "Уухайн дуу" амралтын бааз

Спортын холбоо: Монголын Мөсөн сурын холбоо

Гурав. Ерөнхий шаардлага

3.1.Оролцогч байгууллага: 21 аймаг, 9 дүүрэг байна.

3.1.1.Оролцогчдын үндсэн байгууллага нь амь нас, бэртэл гэмтлийн аюулгүй байдлын гэнэтийн ослын даатгалд даатгуулах, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.

3.1.2.Тэмцээнийг Зохион байгуулах ажлын хэсэг нь спортын холбооны тэмцээний дүрмийн дагуу анхан шат болон сонгон шалгаруулалтаар шалгарсан баг, тамирчдад наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхийг баталгаажуулна.

3.1.3.Тэмцээнийг Зохион байгуулах ажлын хэсэг нь шигшээ тэмцээнд оролцох эрхийн баталгаажилтыг спортын төрөл тус бүрийн тэмцээн эхлэх хугацаанаас 10 хоногийн өмнө баталгаажуулна.

3.1.4.Наадмын шигшээ тэмцээнд оролцох эрх нь баталгаажсан баг, тамирчин нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шигшээ тэмцээнд оролцох боломжгүй болсон тохиолдолд спортын төрөл тус бүрийн эрхийн эцсийн баталгаажилт хийгдэхээс 6 хоногийн дотор Зохион байгуулах ажлын хэсэгт нотлох баримтын хамт Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хорооны албан бичгээр мэдэгдэн, шийдвэрлүүлнэ.

3.1.5. Зохион байгуулах ажлын хэсгээс тэмцээн, наадмын цахим системд бүртгэлтэй дараагийн эрэмбэлэгдсэн баг, тамирчинд анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтын тайланг үндэслэн 4 хоногийн дотор эрхийг шилжүүлэн баталгаажуулна.

3.2. Тамирчинд тавигдах шаардлага:

3.2.1. Тухайн спортын холбооны дүрэмд заасан ангиллаар оролцоно.

3.2.2. Тамирчин анхан шат болон сонгон шалгаруулалтын тэмцээнд бүртгэгдсэн цахим бүртгэлээр шигшээ тэмцээнд оролцоно.

3.2.3. Оролцогчийн гэрээ байгуулсан байна. /цахим гэрээ/

3.2.4. Тэмцээнд оролцогч баг, тамирчин нь харьяалагдах Аймаг, Дүүргийн биеийн тамир, спортын байгууллагаас зохион байгуулах наадмын анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтад заавал орж, нэгдсэн зааврын дагуу Биеийн тамир, спортын тэмцээн, наадмын цахим систем (cpanel.sport.gov.mn)-д заавал бүртгүүлэх, тус бүртгэл нь албан ёсоор баталгаажилт хийгдсэнээр тэмцээнд оролцох эрх үүснэ.

3.2.5. Нэг тамирчин - нэг байгууллага (аймаг, дүүрэг)-нэг спортын төрөлд оролцох ба сонгосон төрөлдөө тухайн спортын олон улсын дүрмийн дагуу зай давхцан оролцож болно.

Дөрөв. Зохион байгуулалт, хугацаа

4.1. Наадмын спортын төрлийн анхан шат болон сонгон шалгаруулалтын тэмцээнийг аймаг, дүүргийн Зохион байгуулах ажлын хэсэг, Биеийн тамир, спортын газар /хороо/-д спортын салбар холбоод хамтран 2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн дотор зохион байгуулна.

4.2. Наадмын өвлийн спортын үндсэн төрөл мөсний шагай, мөсний сурын тэмцээнийг Зохион байгуулах ажлын хэсэг, Биеийн тамир, спортын улсын хороо, спортын холбоод хамтран 2026 оны 01 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулна.

Тав. Тэмцээний үе шат

5.1. Наадмын оролцогч тамирчдыг дараах үе шатаар сонгон шалгаруулна.

5.1.1. Аймаг, дүүрэг анхан шат болон сонгон шалгаруулалт тэмцээн

5.1.2. Шигшээ тэмцээн

5.2. Тамирчин өөрийн сонголтоор харьяалагдах байгууллага, засаг захиргааны нэгжийн аль нэг анхан шат болон сонгон шалгаруулалтын тэмцээнд албан ёсоор оролцож, баталгаажуулалт хийсэн байх

Зургаа. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын үүрэг, хариуцлага

6.1. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтыг нэгдсэн зааварт багтсан спортын төрөл, жин, зай, ангиллаар зохион байгуулна.

6.2. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь тэмцээн, наадмын цахим бүртгэл хариуцсан ажилтныг тусгайлан томилж, баг, тамирчинтай гэрээ (цахим гэрээ) байгуулсан байна.

6.3. Наадамд оролцох баг, тамирчдыг анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалт заавал хийж нэгдсэн зааврын дагуу Биеийн тамир, спортын тэмцээн,

наадмын цахим систем (cpanel.sport.gov.mn)-д заавал бүртгэх, бүртгэлийг баталгаажуулснаар тэмцээнд оролцуулна.

6.4. Анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтаас шалгарсан баг, тамирчдыг шигшээ тэмцээнд оролцуулахад шаардагдах зардлыг Аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газар, Биеийн тамир, спортын газар, хороод бүрэн хариуцна.

6.5. Наадмын анхан шатны тэмцээн болон сонгон шалгаруулалтын үр дүн тайлан, шигшээ тэмцээнд оролцох баг, тамирчдын тоон болон нэрэн мэдүүлгийг 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн дотор наадмын Зохион байгуулах ажлын хэсэгт info@sport.gov.mn хаягаар ирүүлнэ.

6.6. Наадмын шигшээ тэмцээнд оролцох тамирчдыг үдэн гаргах, угтан авах үйл ажиллагааг зохион байгуулж, наадмын явцын мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлж, түгээн сурталчилна.

6.7. Баг, тамирчдыг тэмцээний өдрүүдэд дэх гэнэтийн ослын болон бусад холбогдох даатгалд харьяалах байгууллагын зүгээс зайлшгүй хамруулж даатгуулах үүрэг хүлээнэ.

6.8. Наадмын шигшээ тэмцээний нээлт, хаалтын ажиллагаанд оролцох Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь байгууллагынхаа лого бүхий тугийг барьж жагсана.

6.9. Наадмын шигшээ тэмцээний нэгдсэн зааварт тусгагдсан тамирчны бүртгэлийг санаатай болон санаандгүй зөрчиж, Биеийн тамир, спортын тэмцээн, наадмын цахим систем (cpanel.sport.gov.mn)-д буруу мэдээлэл оруулсан нь тогтоогдвол тухайн байгууллагын удирдлагад Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтыг үндэслэн хариуцлага тооцох үндэслэл болно.

Долоо. Цахим бүртгэл

7.1. Тоон мэдүүлэг

7.1.1. Өвлийн спортын төрлийн тэмцээний баг, тамирчдын тоон мэдүүлгийг цахимаар баталгаажуулж авна. Тоон мэдүүлгийн бүртгэлийн систем 2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрөөс 01 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд батлагдсан загварын дагуу файлаар авна.

7.1.2. Тоон мэдүүлгийг info@sport.gov.mn цахим шуудангаар ирүүлнэ.

7.2. Нэрэн мэдүүлэг

7.2.1. Өвлийн төрлийн тэмцээний баг, тамирчдын нэрэн мэдүүлгийг цахимаар баталгаажуулж авна. Өвлийн спортын нэрэн мэдүүлгийн бүртгэлийн систем 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс нээгдэж 01 дүгээр сарын 16-ны өдрийн 22:00 цагт хаагдана.

7.3. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод цахим бүртгэлд дараах оролцогчдыг бүртгүүлнэ. Үүнд:

- Тамирчин
- Дасгалжуулагч

7.4. Зохион байгуулагчийн цахим бүртгэлд дараах ажилтнуудыг бүртгэнэ. Үүнд:

- Зохион байгуулагч
- Албаны ажилтан
- Хүндэт зочин

7.5. Харьяалах байгууллага, спортын хороог бүртгэнэ. Үүнд:

- Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар хороо

7.6.Тэмцээн Зохион байгуулах ажлын хэсгээс баталсан цахим бүртгэлийн зааварчилгааг оролцогч байгууллагуудад 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнө хүргүүлж, тухай бүрд сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

7.7.Зохион байгуулах ажлын хэсгийн цахим бүртгэлийн ажлын хэсэг цахим бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хариуцаж, хяналт тавьж ажиллана.

7.8.Цахим бүртгэлтэй холбоотой мэдээллийг www.sport.gov.mn цахим хуудсанд байршуулна.

Найм. Спортын холбоодын үүрэг, хариуцлага

8.1.Монголын Үндэсний спортын VIII наадмын өвлийн төрлийн шигшээ тэмцээний хөтөлбөрт багтсан спортын төрлийн холбоод нь Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 20 дугаар зүйл "Спортын холбоо, түүний эрх, үүрэг"-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллана.

8.2.Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөл тус бүрийн тэмцээний зааврыг тухайн спортын холбооноос боловсруулан баталж, наадмын Зохион байгуулах ажлын хэсэгт ирүүлнэ.

8.3.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Биеийн тамир, спортын улсын хороо, наадмын шигшээ тэмцээнийг зохион байгуулах эрх авсан спортын холбоодтой "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, тэмцээнийг удирдан зохион байгуулна.

8.4.Спортын холбоод нь шигшээ тэмцээний хөтөлбөр, бэлтгэл ажил, тэмцээн зохион байгуулах талбайн тохижилт, тамирчдын аюулгүй байдал, шаардагдах спортын хэрэгсэл, хэрэглэл материал, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, нөөц хангамж, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, нээлт, хаалт, шагнал гардуулалд, эмч шүүгч ажиллуулах, тамирчдын бие халаалт хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх, бусад зохион байгуулалтыг хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

8.5.Спортын холбоод нь тухайн төрлийн шигшээ тэмцээнийг шүүн явуулах Шүүгчийн бүрэлдэхүүнийг томилон баталгаажуулж наадмын Зохион байгуулах ажлын хэсэгт тэмцээн эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө ирүүлсэн байна. Шүүгчийн зөвлөл нь тухайн спортын төрлийн техникийн зөвлөгөөнийг удирдан зохион явуулна.

8.6.Спортын холбооноос томилогдсон тэмцээний ерөнхий шүүгч, маргаан таслах зөвлөл нь багийн ахлагч, багийн дасгалжуулагчаас гаргасан хүсэлт, гомдлыг шийдвэрлэнэ.

8.7.Шигшээ тэмцээний спортын төрөл тус бүрийг хариуцсан ерөнхий шүүгч нь тэмцээний үр дүнг гарын үсэг тамгаар баталгаажуулж наадмын Зохион байгуулах ажлын хэсэгт 2 цагийн дотор хүргүүлэн ажиллах үүрэгтэй.

Ес. Санхүүжилт

9.1.Наадмын спортын төрлүүдийн анхан шатны тэмцээний зохион байгуулалттай холбоотой зардлыг тухайн Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод хариуцна.

9.2.Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод шигшээ тэмцээнд баг тамирчдаа оролцуулахтай холбоотой зардлыг хариуцна.

9.3.Наадмын шигшээ тэмцээний зохион байгуулалтад шаардагдах зардлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, Зохион байгуулах ажлын хэсэг хариуцна.

Арав. Сахилга бат, дэг журам

10.1.Монголын үндэсний спортын VIII наадмын өвлийн төрлийн шигшээ тэмцээнд оролцогч нь Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйл. "Биеийн

тамир, спортод эрхэмлэн баримтлах ёс зүйн хэм хэмжээ"-д заасан хэм хэмжээг сахин мөрдөнө.

10.2.Спортоор дамжуулж тамирчдад сахилга бат, ёс зүйтэй байх, нийгэмд зөв хандлага, эерэг нөлөөллийг бий болгоно.

10.3.Баг, тамирчин нь наадмын үйл ажиллагаа, тэмцээний талбай, зам, гараа, барианы тогтсон байршилд, нэгдсэн зохион байгуулалтад орж үүрэг хариуцлага, хувь хүний харилцаа хандлагыг бүрэн ухамсарлаж хэрэгжүүлнэ.

10.4.Өрсөлдөгч нараа хүндэтгэн, шударга өрсөлдөөнийг үзүүлнэ.

Арван нэг. Хүсэлт, гомдол шийдвэрлэх

11.1.Хүсэлт, гомдлыг зөвхөн тухайн багийн ахлагч, баг хариуцсан дасгалжуулагч нь бичгээр үйлдэн (шалтгаан, багийн нэр, хаяг, гарын үсэг, сар, өдрийг тодорхой бичих) өөрийн биеэр тухайн тэмцээний ерөнхий шүүгчид хандана.

11.2.Хүсэлт, гомдлыг спортын холбооноос томилогдсон тэмцээний ерөнхий шүүгч, маргаан таслах зөвлөл шийдвэрлэнэ. Шигшээ тэмцээн дуусаж дүн гаргахаас өмнө санал, хүсэлт, гомдол гаргасан тохиолдолд хүлээн авч шийдвэрлэнэ.

11.3.Наадмын шигшээ тэмцээний цахим бүртгэлтэй холбоотой гаргасан хүсэлт, гомдол нь үндэслэлтэй байх шаардлагатай бөгөөд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, наадмын Зохион байгуулах ажлын хэсэг шийднэ.

Арван хоёр. Дүгнэх аргачлал, шагнал урамшуулал

12.1. Монголын Үндэсний спортын VIII наадмын өвлийн төрлийн шигшээ тэмцээнд оролцогч байгууллагуудыг спортын 2 төрлийн нэгдсэн дүнгээр медалийн чанараар байр эзлүүлж дүгнэнэ.

12.1.1. Монголын үндэсний спортын VIII наадмын өвлийн төрлийн шигшээ тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдад Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

12.1.2.Спортын төрөл тус бүрд медалийн чанараар байгууллагын дүн гаргаж, медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

12.1.3.Наадмын шигшээ тэмцээнд амжилттай оролцсон эхний 6 (зургаа) Аймгийг цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

12.1.4.Наадмын шигшээ тэмцээнд амжилттай оролцсон эхний 3 (гурав) Дүүргийг цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

---oOo---